



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар A/152.

Бат-Өлзий сум

Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дах хэсэг, Засгийн газрын “Журам батлах тухай” 2017 оны 144 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Ээлжит цэрэг татлага явуулах тухай” 2022 оны А/427 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны ээлжит цэрэг татлагын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Дарга: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд. Ж.Булганзаяа (Эрүүл мэндийн төвийн дарга)

Д.Очирбат (Соёлын төвийн дарга)

Д.Энх-Амгалан (Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад)

Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)

С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)

Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)

Г.Цэрэндулам (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Б.Ууганцэцэг (Нийгмийн даатгалын байцаагч)

Ө.Гөлгөө (Улсын бүртгэгч)

Г.Сарантуяа (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Г.Дуламдорж (Насан туршийн боловсролын арга зүйч)

Г.Сугар (Хууль эрх зүйн хөтөч)

С.Ганхүлэг (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Сумын цэрэг татлагын ажлын хэсгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг хавсралтаар баталсугай.


3. Цэргийн жинхэнэ албанд татагдаж буй иргэдэд эрүүл мэндийн үзлэг явуулах эмч, мэргэжилтнүүдийг ажиллуулах, шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлэн байлгах, цэрэг татлагын үйл ажиллагааны үеэр ариутгал, халдвартгүйжүүлэлтийн горимыг чанд сахиж, Эрүүл мэндийн төвөөс мэргэжлийн албан тушаалтнуудыг томилж ажиллуулахыг Эрүүл мэндийн төвийн дарга, их эмч (Ж.Булганзаяа)-д, цэрэг татлага явуулах байр бэлтгэхийг Соёлын төвийн дарга (Д.Очирбат) нарт тус тус даалгасугай.

1322201327

4. Цэрэг татлагын үеэр нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад (Д.Энх-Амгалан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



Сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 29-ны
өдрийн А/158 дугаар захирамжийн хавсралт

**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЦЭРЭГ ТАТЛАГЫН
АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ**

№	Хийж гүйцэтгэх ажил	Хүргэцаа	Хариуцах албан тушаалтан	Ажлын хуваарь танилцуулсан байдал
1.	Цэргэг татлагын ажлын хэсэг хуралдах	9 сарын 29	ЗДТГ-ын дарга	
2.	Цэргэг татлагын ажилд шаардагдах хөрөнгийг сумын ИТХ-аар батлуулан шийдвэрлэсэн байна	09 сарын 29	ЗДТГ-ын дарга	
3.	Эрүүл мэндийн төв, багийн эмч нартайгаа хамтран эрүүлжүүлэх боломжтой 18-25 насны залуучуудыг цэргэг татлагаас өмнө эмчийн үзлэгт хамруулан суманд эмчлэх боломжтойг нь эмчлэн эрүүлжүүлж, цэргийн албанд тэнцүүлэх арга хэмжээг авна.	10 сарын 08-ны дотор	ЗДТГ-ын дарга ЭМТөвийн дарга Ж.Булганзаяа БЗДарга нар	
4.	Цэргэг татлагын комиссын бэлтгэл ажлыг хэрхэн хангаж ажилласан талаар мөн дайчилгааны бэлэн байдлын талаар танилцуулга сонсох 5-10 минутын танилцуулгыг компьютерийн үйлдлийн системийн Power Pont программ дээр бэлтгэх	10 сарын 08	ЗДТГ-ын дарга	
5.	Цэргэг татлагын үеэр ариутгал, халдвартгүйжүүлэлтийн горимыг сахиж, цэргэг татлагын байранд ЭМТөв өдөрт 2 удаа ариутгал халдвартгүйжүүлэлт хийж, нэг дор 20-оос дээш цэргэг татагдагч иргэн цуглуулахгүйгээр цагийн нарийвчлалтайгаар эрүүл мэндийн үзлэгт оруулна.	10 сарын 09	ЭМТөв, Багийн Засаг дарга нар	
6.	Цэргэг татлагын комисст амны хаалт болон гар ариутгагчаар бүрэн хангах.	10 сарын 09	ЗДТГ-ын дарга	
7.	Цэргэг татагдагчдын нэрсийн бүртгэлийг 18-25 насны болон 1997-2004 онд төрсөн иргэдийн овог нэр, регистрийн дугаарыг	10 сарын 05	Багийн Засаг дарга нар БХЭрхлэгч	

	Цэргийн штабаас Excel программ дээр боловсруулсан үйлдлийн системийн дагуу нэг бүрчлэн бичиж оруулан бэлэн болгох			
8.	Зарлан дуудах мэдэгдлийг цэрэгт татагдагч иргэн бүрт гардуулан өгч, хүлээн авсан этгээдээр гарын үсэг зуруулж, буцаах тасалбараар Тамгын газрын даргатай тооцоо хийсэн байх.	10 сарын 08	ЗДТГ-ын дарга Багийн Засаг дарга нар	
9.	Иргэний үнэмлэх аваагүй иргэдийг үнэмлэхжүүлэх	10 сарын 09-ны дотор	Улсын бүртгэгч Θ.Гөлгөө	
10.	Цэрэгт татагдагч иргэн бүр иргэний үнэмлэх, цэргийн Үүрэгтний үнэмлэх, ЭМД-ын дэвтэр, НД-ын дэвтэр, өвчлөл бүхий иргэд картаа заавал авч ирсэн байх, ар гэрийн гачигдлын учир чөлөөлүүлэхийг хүссэн иргэд багийн Засаг даргын тодорхойлолт, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж, сумын цэрэг татлагын товчоогоор нэг бүрчлэн хэлэлцүүлж зохих журмын дагуу шийдвэрлэсэн байна.	10 сарын 07-ны дотор	ЗДТГ-ын дарга Багийн Засаг дарга нар Нийгмийн даатгалын байцаагч Улсын бүртгэгч	
11.	Цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэг явуулах байрыг дулаан, гэрэлтүүлэг сайтай байлгах, хивс дрож дэвссэн, агааржуулалтын шаардлага ханган, ажиллах нөхцөл боломжоор бүрэн хангах.	10 сарын 09	Д.Очирбат Ж.Булганзаяа	
12.	Цэрэгт татагдагчдын анкетыг шинэчлэгдсэн загвараар нээж 2 хувь үнэн зөв компьютерээр бичиж, зураг наан, ам бүлийн талаар шинэчлэн тодотгож дэлгэрэнгүй бичих	10 сарын 08-ны дотор	Багийн Засаг дарга нар	
13.	Цэрэг татлагаар их, дээд сургуулиудын нэгдүгээр дамжаа буюу шинэ оюутнуудыг дуудахгүйгээр бусад дамжааны оюутан сурагчдыг “Цэргийн албаны тухай” хуулийн дагуу цэрэг татлагад бүрэн хамруулах учир оюутан, сурагчид, цэрэг татлагад ирэхдээ сургуулийн тодорхойлолт, төлбөр төлсөн баримтыг үндэслэн цэрэгт татах эсэх талаар шийдвэр гаргана.	10 сарын 09	Багийн Засаг дарга нар	
14.	Засгийн газрын 2021 оны 41, 2022	10 сарын		

	оны 120 дугаар тогтоолуудын дагуу 1995, 1996 оны цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол хангасан иргэдэд мөнгөн төлбөр тогтоох, мөнгөн төлбөрийг барагдуулахад иргэдийг бэлэн байлгах	08-ны дотор	Багийн Засаг дарга нар Г.Доржханд	
15.	Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж буй иргэдийг холбогдох бичиг баримтын хамт бэлэн байлгах, ажлын үр дүнг хүн нэг бүрээр тооцох	10 сарын 08	ЗДТГ-ын дарга Багийн Засаг дарга нар	
16.	Цэрэг татлагын комиссоор орох бүх иргэдэд цэргийн үүрэгтний үнэмлэх бүрэн олгогдсон байх	10 сарын 09	ЗДТГ-ын дарга Г.Дуламдорж	
17.	Зарлан дуудах хуудастай хамт бөглөсөн мэдэгдэх хуудсыг бэлэн байлгах, 2022 онд 18-25 насны бүх иргэдэд зарлан дуудах мэдэгдэл хүргүүлэх /сараар 18 насанд хүрээгүй иргэнд зарлан дуудах хуудас хүргүүлээгүй гэсэн асуудал гаргахгүй байх/	10 сарын 08	Багийн Засаг дарга нар	

--Оо--